



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 06 өдөр

Дугаар А/60

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, "Үйлдвэрлэгч- Ховд " хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор ЗАХИРАМЖЛАХ нь:


1. "Үйлдвэрлэгч -Ховд" хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор төсөл сонгон шалгаруулалт явуулсан дүн, байгуулсан гэрээ, санхүүжилтийн эрхийг үндэслэн хавсралтанд заасан аж ахуйн нэгжүүдэд 160,0 сая төгрөгийн зээл олгосугай.

2. Зээл олгох аж ахуйн нэгжийг хавсралтаар баталсугай.

3. Дээрхи арга хэмжээнд зарцуулах 160.0 сая /Нэг зуун жаран сая/ төгрөгийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 10/06 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтын 5.31-д заасан "Үйлдвэрлэгч Ховд" өрхийн жижиг дунд үйлдвэрлэл, бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөрийн санхүүжилтээс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал /, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ц.Ганданповрон/ нарт зөвшөөрсүгэй.

4. Энэхүү захирамжийн хэрэгжилт, зээлийг зориулалтын дагуу зарцуулагдаж буй эсэхэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-д даалгасугай .


ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

02 00265
DIZax-A/60-Da

Аймгийн Засаг даргын 2020 оны
02 дугаар сарын 06-ны өдрийн
А/60 дугаар захирамжийн хавсралт



“ҮЙЛДВЭРЛЭГЧ-ХОВД” ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД
АЖ АХУЙН НЭГЖИД ОЛГОХ ЗЭЭЛИЙН ХЭМЖЭЭ

Д/д	Аж ахуйн нэгжийн нэр	Төслийн нэр	Хүссэн зээл	Олгох зээл
1.	“Тарвагатайн бэлчир” ХХК	Гагнуурын үйлдвэрлэл үйлчилгээ	20.000.000	7.000.000
2.	“Алтай нутгийн дээж” БГБХН	Бэлэг дурсгалын сувинер	20.000.000	5.000.000
4.	Иргэн Т.Бямбатөмөр	“Баянбүрд мод үржүүлгийн газар байгуулах	10.000.000	10.000.000
5.	Иргэн Д.Баярмандал	“Ач Оюундалай” лаборатори, эмнэлгийн тоног төхөөрөмж шинэчлэх	10.000.000	10.000.000
6.	“Хүсэл тэмүүлэлийн дөл” ХХК	Сийлбэртэй модон эдлэл	50.000.000	30.000.000
7.	“Мянгат чаргат” хоршоо	Ингэний хоормогоор бүтээгдэхүүн үйлдвэрлэх	30.000.000	20.000.000
12.	“Өв эс” ХХК	Хими цэвэрлэгээний үйл ажиллагааг өргөтгөх	50.000.000	20.000.000
13.	Иргэн Б.Баярхүү	Жуулчны баазын үйл ажиллагааг өргөтгөх	30.000.000	20.000.000
15.	“Цагаан шувуут тулга” ХХК	Банш, буузны цех өргөтгөх	20.000.000	10.000.000
16.	“Ховд скай” ХХК	Савласан тараг сүү үйлдвэрлэх	74.000.000	28.000.000
	Нийт дүн			160.000.000